Мандал Ирээдүйн Өсөлт

Хамтын ХОС ХХК

.баатар дүүрэг, 1-р хороо, Жамьян гүний гудамж, Меру тауэр, 602 тоот
Шуудангийн хайрцаг – 2292,
Улаанбаатар – 15160, Монгол улс
Утас: (976) 7272 9911

*2024 оны 04 сарын 30* *Дугаар №24/ 052* *Улаанбаатар хот*

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИД

*Тайлан хүргүүлэх тухай*

“Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС” ХХК нь Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 3-р сарын 23-ны өдрийн 145 тоот тогтоолоор батлагдсан “Компанийн засаглалын кодекс”-ийн Хавсралт 01 “Компанийн засаглалын үйл ажиллагааны тайлангийн маягт”-ын дагуу засаглалын хэрэгжилтийг үнэлэн хавсралтаар хүргүүллээ.

*Хавсралт: 9 хуудас*

*Хүндэтгэсэн,*

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Г.ГАНЗОРИГ

УЛААНБААТАР ХОТ
МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ ХАМТЫН ХОС ХХК
9021060636 рд. 6702988

МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН

# "КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС" ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

(2024 ОН)

УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ ХАМТЫН ХОС ХХК 9021060636 Ж 6702938

# “МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ ХАМТЫН ХОС” ХХК

## Компанийн засаглалын кодексийн үнэлгээний хэрэгжилтийн тайлангийн товч тойм

Санхүүгийн зохицуулах хорооноос 2022 оны 3-р сарын 23-ны өдөр шинэчлэн баталсан “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг үнэлэх зорилгоор баталсан “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн өөрийн үнэлгээг МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ ХАМТЫН ХОС” ХХК зохих аргачлалын дагуу үнэлсэн болно.

Санхүүгийн зохицуулах хорооноос мөн баталсан “Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийг зохион байгуулах ажлын удирдамж”-ийн дагуу 36 асуулга бүхий үнэлгээний загвараар өөрийн үнэлгээг хийсэн.

**Үнэлгээний оноо**

Асуулга тус бүрийн хүрээнд хийгдвэл зохих ажлын хэрэгжилтийг 0-2 оноогоор үнэлж түүнийгээ хувьд шилжүүлэн, үнэлгээг 0-100 хувиар тооцож гаргасан болно.

- Бүрэн хэрэгжүүлсэн, эсхүл үндэслэл бүхий тайлбар гаргасан бол 2 оноо;
- Хэсэгчлэн хэрэгжүүлсэн, эсхүл хугацаа бүхий хэрэгжүүлэх арга хэмжээ, зорилтоо тайлбарласан бол 1 оноо;
- Хэрэгжүүлээгүй, үнэлгээ ирүүлээгүй бол 0 оноо.

“Компанийн засаглалын кодекс”-ийн нэгдсэн үнэлгээгээр авбал зохих онооны 94.3 хувь үнэлгээг авч, засаглал сайн, эрсдэлгүй гэсэн ангилалд хамрагдаж байна гэж дүгнэлээ.

# “МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ ХАМТЫН ХОС” ХХК

**Компанийн засаглалын үнэлгээний асуулга**

*Кодексийн хэрэгжилтийг “Хэрэгжүүл, эсвэл тайлбарла” гэсэн зарчмын дагуу тайлагнах ба кодексийн зүйл тус бүрээр биелүүлсэн эсэх, биелүүлээгүй бол яагаад биелүүлээгүй, түүнийг орлох бүтэц, зохион байгуулалтын арга хэмжээ авсан, эсхүл авч байгаа, хэрэв төлөвлөж буй бол хугацаатайгаар нь тайлбар хэсэгт тусгана.*

**НЭГ. ТУЗ-ИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

**ТУЗ нь олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал зэргийг зохистойгоор хангасан, алсын хараатай, бүтээлч, үр дүнтэй бүтэц байна.**

| № | Зүйл | Хэрэгжилт | Тайлбар | Оноо | Хувь |
|---|---|---|---|---|---|
| 1 | ***1.1. Компани нь ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын чиг үүрэг, хариуцлагыг нарийвчлан зохицуулна.*** | Хэсэгчлэн хэрэгжүүлсэн. | “Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС”-ийн Хувьцаа эзэмшигчийн 2021 оны 8 сарын 24-ний өдрийн 21/086 дугаар тогтоолын хавсралт А-гаар баталсан сангийн дүрмийн 10 дугаар зүйлд заасан. Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагаа, нарийн бичгийн даргын үйл ажиллагааны журмын төслийг Төлөөлөн удирдах зөвлөлийн 5 дугаар сард болох ээлжит хурлаар хэлэлцүүлэхээр төлөвлөж байна. | 1 | 70% |
| 2 | ***1.2. Компани нь ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, томилох асуудлыг тусгасан нэр дэвшүүлэх журам, залгамж халааны бодлогын баримттай байна.*** | Бүрэн хэрэгжсэн. | Сан нь ХК-аас ялгаатай, ТУЗ нь 5 гишүүнтэй тул тусдаа хороо байгуулахгүйгээр ТУЗ нь нэр дэвшүүлэх, сонгон шалгаруулалттай холбоотой чиг үүргийг хэрэгжүүлж байхаар шийдвэрлэсэн. Залгамж халааны бодлогын баримт бичгийн төслийг боловсруулсан. ТУЗ-ийн ээлжит хурлаар хэлэлцэх төлөвлөгөөтэй ажиллаж байгаа. Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журмын 5 болон 6 дугаар зүйлд тусгасан. | 2 | 90% |
| 3 | ***1.3. ТУЗ-ийн гишүүн бүрийн ажлын туршлага, ажилласан хугацаа, хараат бус байдал, хувьцааны эзэмшлийн хувь хэмжээ, хуралдаанд оролцсон ирц зэрэг мэдээллийг жилийн үйл ажиллагааны тайланд дэлгэрэнгүйгээр тусгаж, цахим хуудсандаа байршуулна.*** | Бүрэн хэрэгжсэн. | ТУЗ-ийн гишүүн бүрийн ажлын туршлага, ажилласан хугацаа, хараат бус байдал, хувьцааны эзэмшлийн хувь хэмжээг жилийн үйл ажиллагааны тайланд тусгаж, мөн цахим хуудсандаа байршуулсан. “Мандал Ирээдүйн Өсөлт” нь өөрийн хөрөнгө оруулалт менежментийн компанийн https://mandalasset.mn/funds/mfg цахим хуудсаар дамжуулан хөрөнгө оруулагчдадаа мэдээлэл хүргэдэг. | 2 | 100% |
| 4 | ***1.4. Компани нь ТУЗ болон түүний дэргэдэх хороодын бүтэц, бүрэлдэхүүний бодлогын баримттай байх ба уг баримт бичигт гишүүний боловсрол, мэргэшил, ур чадвар, туршлагад тавигдах шаардлага болон хүйсийн тэнцвэрт байдал зэргийг тусгана.*** | Хэсэгчлэн хэрэгжүүлсэн. | “Мандал Ирээдүйн Өсөлт” ТУЗ-ийн 5 гишүүнтэй бөгөөд ТУЗ-ийн 9 гишүүнтэй ХК-тай адил олон хороодтой байх нь тохиромжгүй буюу сангийн ТУЗ-ийн хараат бус гишүүн ачаалалтай болох билээ. *“Компани энэхүү кодексийн засаглалын зарчмуудыг бүрэн хэрэгжүүлэхийг эрмэлзэх ба компанийн үйл ажиллагааны онцлог, бүтэц, хэмжээ, хөгжлийн үе шат зэргээс шалтгаалан зарим нэг зүйлийг тухайлан хэрэгжүүлэх боломжоогүй, эсвэл зохион байгуулалтын илүү зохистой арга хэмжээг авч хэрэгжүүлж болно”* гэж зохицуулагч байгууллагаас зөвлөсний дагуу ТУЗ-ийн дэргэдэх хороодтой байх эсэхийг ярилцаж байгаа. Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмын төслийн 3 дугаар зүйлд ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг заасан. | 1 | 70% |
| 5 | ***1.5. ТУЗ-ийн гишүүнийг анх томилогдоход чиглүүлэх сургалтыг зохион байгуулах ба ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ур чадвар, мэдлэг, мэдээллийг олгох, тэдгээрийг шинэчлэх сургалтад тогтмол хамруулна.*** | Бүрэн хэрэгжсэн. | Компанийн дотоод сургалт, Компанийн засаглалын гүнзгийрүүлсэн сургалт, Үнэт цаасны зах зээлийн бусад сургалтад хамрагдах нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна. | 2 | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 6 | ***1.6. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн үйл ажиллагааг зохистой явуулах асуудлаар ТУЗ-ийн даргаар дамжуулан хариуцлага хүлээнэ.*** | Бүрэн хэрэгжүүлсэн. | Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь Хорооны шаардлагын дагуу Компанийн засаглалын гэрчилгээтэй тохиромжтой этгээд юм. Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргын үйл ажиллагааны журмыг ТУЗ-ийн хурлаар батлуулахаар ажиллаж байна. | 2 | 90% |
| ДҮН | | | | 10 | 86.6% |
| **ХОЁР. ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД, ТЭДГЭЭРИЙН ЧИГ ҮҮРЭГ**<br>**ТУЗ нь өөрийн үйл ажиллагааг тодорхой чиг үүрэг хариуцсан өөрийн дэргэдэх хороодоор дамжуулан хэрэгжүүлж, эцсийн хариуцлагыг хүлээнэ** | | | | | |
| 7 | ***2.1. ТУЗ-ийн дарга болоод ТУЗ-ийн гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байхыг зорино.*** | Бүрэн хэрэгжүүлсэн. | Хөрөнгө оруулалтын сан нь бусад компаниас өөр зохицуулалттай бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн 275 тоот тогтоолоор батлагдсан "Хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түүнд хяналт тавих журам"-ын 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэгт зааснаар Сангийн дүрэмд өөрөөр заагаагүй бол хамтын ХОС-ийн төлөөлөн удирдах зөвлөл нь 5-аас доошгүй гишүүнтэй, тэдгээрийн гуравны нэгээс доошгүй нь хараат бус гишүүн байх гэдэг шаардлагыг ханган ТУЗ-ийн дарга болон 2 гишүүн нь хараат бус гишүүн байдаг. | 2 | 100% |
| 8 | ***2.2. ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо нь үйл ажиллагааны журам аудитын бодлогын баримт бичигтэй байна. Аудитын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус байна. Аудитын хорооны хуралд компанийн гүйцэтгэх удирдлага болон ажилтнууд гагцхүү тус хорооны хүсэлтээр оролцоно.*** | *"Компани энэхүү кодексийн засаглалын зарчмуудыг бүрэн хэрэгжүүлэхийг эрмэлзэх ба компанийн үйл ажиллагааны онцлог, бүтэц, **хэмжээ**, хөгжлийн үе шат зэргээс шалтгаалан зарим нэг зүйлийг тухайлан хэрэгжүүлэх боломжгүй, эсвэл зохион байгуулалтын илүү зохистой арга хэмжээг авч хэрэгжүүлж болно"* | "Мандал Ирээдүйн Өсөлт" ТУЗ-ийн 5 гишүүнтэй бөгөөд ТУЗ-ийн 9 гишүүнтэй ХК-тай адил олон хороодтой байх нь тохиромжгүй буюу сангийн ТУЗ-ийн хараат бус гишүүн нилээдгүй ачаалалтай болох билээ.<br>*"Компани энэхүү кодексийн засаглалын зарчмуудыг бүрэн хэрэгжүүлэхийг эрмэлзэх ба компанийн үйл ажиллагааны онцлог, бүтэц, **хэмжээ**, хөгжлийн үе шат зэргээс шалтгаалан зарим нэг зүйлийг тухайлан хэрэгжүүлэх боломжгүй, эсвэл зохион байгуулалтын илүү зохистой арга хэмжээг авч хэрэгжүүлж болно"* гэж зохицуулагч байгууллагаас зөвлөсний дагуу ТУЗ-ийн дэргэдэх хороодтой байх эсэхийг ярилцаж байгаа.<br>Эрсдэл, аудитын хороог байгуулах, үйл ажиллагааны журмыг боловсруулах ажлыг хийж эхэлсэн. | 2 | 80% |
| 9 | ***2.3. ТУЗ-ийн дэргэдэх цалин урамшууллын хороо нь цалин, урамшууллын үйл ажиллагааны журам, цалин урамшууллын бодлогын баримт бичигтэй байна. Цалин урамшууллын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна. Цалин урамшууллын хорооны хуралд гүйцэтгэх удирдлага гагцхүү хорооны хүсэлтээр оролцоно.*** | *"Компани энэхүү кодексийн засаглалын зарчмуудыг бүрэн хэрэгжүүлэхийг эрмэлзэх ба компанийн үйл ажиллагааны онцлог, бүтэц, **хэмжээ**, хөгжлийн үе шат зэргээс шалтгаалан зарим нэг зүйлийг тухайлан хэрэгжүүлэх боломжгүй, эсвэл зохион байгуулалтын илүү зохистой арга хэмжээг авч хэрэгжүүлж болно"* | Хөрөнгө оруулалтын сан нь ажилтангүй бөгөөд цалингийн зардал гаргадаггүй тул Цалин урамшууллын хороогүй байна.<br>Санг удирдаг Мандал Ассет Менежмент ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь цалин урамшууллын бодлогын баримт бичигтэй. | 2 | 100% |
| 10 | ***2.4. ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороо нь үйл ажиллагааны журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна. Нэр дэвшүүлэх хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна.*** | *"Компани энэхүү кодексийн засаглалын зарчмуудыг бүрэн хэрэгжүүлэхийг эрмэлзэх ба компанийн үйл ажиллагааны онцлог, бүтэц, **хэмжээ**, хөгжлийн үе шат зэргээс шалтгаалан зарим нэг зүйлийг тухайлан хэрэгжүүлэх боломжгүй, эсвэл зохион байгуулалтын илүү зохистой арга хэмжээг авч хэрэгжүүлж болно"* | "Мандал Ирээдүйн Өсөлт" сан нь ажилтангүй. ТУЗ-ийн 5 гишүүнтэй бөгөөд ТУЗ-ийн 9 гишүүнтэй ХК-тай адил олон хороодтой байх нь тохиромжгүй буюу сангийн ТУЗ-ийн хараат бус гишүүний ачаалал нэмэгдэх билээ. Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмын төслийн 5 дугаар зүйлд ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх, 6 дугаар зүйлд ТУЗ-ийн гишүүнээр сонгох ба чөлөөлөх талаар тусгасан. Залгамж халааны бодлогын баримт бичгийн төслийг боловсруулсан. ТУЗ-ийн ээлжит хурлаар хэлэлцэх төлөвлөгөөтэй ажиллаж байгаа. | 2 | 80% |
| 11 | ***2.5. ТУЗ нь өөрийн дэргэд бусад чиг үүрэг бүхий байнгын болон түр хороог*** | *"Компани энэхүү кодексийн засаглалын зарчмуудыг бүрэн хэрэгжүүлэхийг эрмэлзэх ба* | ТУЗ-ийн дэргэдэх хороодтой байх эсэхийг ярилцаж байгаа. | 2 | 80% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | ***байгуулж болно. ТУЗ-ийн дэргэдэх хороод бүгд үйл ажиллагааны журам, заавартай, чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, ажлын туршлага бүхий бүрэлдэхүүнтэй байна.*** | *компанийн үйл ажиллагааны онцлог, бүтэц, хэмжээ, хөгжлийн үе шат зэргээс шалтгаалан зарим нэг зүйлийг тухайлан хэрэгжүүлэх боломжгүй, эсвэл зохион байгуулалтын илүү зохистой арга хэмжээг авч хэрэгжүүлж болно”* | Эрсдэл, аудитын хороог байгуулах, үйл ажиллагааны журмыг боловсруулах ажлыг хийж эхэлсэн. | | |
| ДҮН | | | | 10 | 88% |
| **ГУРАВ. ТАЙЛАГНАЛ, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ**<br>**ТУЗ нь санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал, мэдээллийн ил тод байдлын үнэн, бүрэн, тэнцвэрт байдлыг хангана** | | | | | |
| *12* | ***3.1. ТУЗ нь компанийн мэдээллийн ил тод байдал, тайлагналын журмыг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина.*** | Бүрэн хэрэгжүүлсэн. | “Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС”-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 6 сарын 14-ний өдрийн 21/007 дугаар тогтоолын Хавсралт А-гаар баталсан “Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС”-ийн нийтэд болон сангийн нэгж эрх эзэмшигчдэд мэдээлэл өгөх журмыг баталсан. | 2 | 100% |
| *13* | ***3.2. ТУЗ нь энэхүү кодекст заасан засаглалын баримт бичиг, дүрэм, журам, заавbegрыг цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд хүргэнэ.*** | Хэсэгчлэн хэрэгжүүлсэн. | ТУЗ-ийн гишүүдийн мэдээлэл болон Мэдээллийн ил тод байдал, тайлагналын журмыг цахим хуудсанд байршуулсан. Бусад дүрэм журмуудыг нийтлэхээр төлөвлөж байна.<br>Цахим хуудасны линк хавсаргав.<br>https://mandalasset.mn/funds/mfg | 2 | 80% |
| *14* | ***3.3. Санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал нь тэнцвэртэй, тодорхой, бодит байна. Санхүүгийн бус тайлан нь хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засгийн хүрээнд компанийн тогтвортой үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй хүчин зүйлс, эрсдэл, компанийн үйл ажиллагааны зорилго, зорилтуудаа хүрсэн эсэхийг үнэлсэн мэдээлэл байна.*** | Бүрэн хэрэгжүүлсэн. | Санг удирддаг “Мандал Ассет Менежмент ҮЦК” ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2022 оны 04 сарын 23-ны өдрийн 31 тоот тушаалын хавсралт №1 Ногоон хөгжлийн бодлого болон хавсралт №2 Нийгмийн хариуцлагын бодлогын баримт бичгийг батлан удирдаж буй сангуудаа хэрэгжүүлэн ажиллаж байна.<br>Санхүүгийн тайлан нь олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу бэлтгэгдэж, хөндлөнгийн МҮҮРЬ аудитаар баталгаажсан.<br>https://mandalasset.mn/funds/mfg цахим хуудсаар үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн аудитлагдсан тайланг олон нийтэд нээлттэй мэдээлдэг. | 2 | 100% |
| ДҮН | | | | 6 | 93.3% |
| **ДӨРӨВ. АУДИТ, ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО**<br>**ТУЗ нь аудит, хяналтын тогтолцооны хараат бус, үр дүнтэй байдлыг хангана** | | | | | |
| *15* | ***4.1. ТУЗ нь аудитын хорооны үйл ажиллагааны журамд хөндлөнгийн аудитортой харьцах, түүнийг хуульд заасан чиг үүргээ саадгүй гүйцэтгэх нөхцөл боломжоор хангах талаар тусгаж, хэрэгжилтэд нь хяналт тавина.*** | Хэсэгчлэн хэрэгжүүлсэн. | Эрсдэл, аудитын хороог байгуулах, үйл ажиллагааны журмыг боловсруулах ажлыг хийж эхэлсэн. Уг журамд хөндлөнгийн аудитортай харьцах, түүнийг хуульд заасан чиг үүргээ саадгүй гүйцэтгэх нөхцөл боломжоор хангах талаар тусгасан. | 1 | 70% |
| *16* | ***4.2. Хөндлөнгийн аудитор нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцож, аудиттай холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгдөг байна.*** | Бүрэн хэрэгжүүлсэн. | Хувьцаа эзэмшигчдэд тогтмол мэдээлэл өгдөг. Сангийн 2024 оны 04 сарын 22-ны өдөр болсон Нэгж эрх эзэмшигчдийн хурлаар хөндлөнгийн аудитын дүгнэлтийг танилцуулсан.<br>Хөндлөнгийн аудитор НЭЭ хуралд оролцоогүй. | 2 | 90% |
| *17* | ***4.3. Дотоод аудитын тогтолцоо, түүний*** | Бүрэн хэрэгжүүлсэн | Сан нь дотоод хяналтын хороотой бөгөөд “Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС”-ийн Төлөөлөн | 2 | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 18 | ***бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, тэдгээрт орсон өөрчлөлтийн талаарх мэдээллийг компанийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар олон нийтэд тухай бүр мэдээлнэ.*** | | удирдах зөвлөлийн 2021 оны 6 сарын 14-ний өдрийн 21/007 дугаар тогтоолын Хавсралт А-гаар Дотоод хяналтын журмыг баталсан. | | |
| ДҮН | | | | 5 | 86.6% |
| **ТАВ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА**<br>**ТУЗ нь эрсдэлийн удирдлага болон комплайнсын хяналтыг зохистой байдлаар, хараат бусаар зохион байгуулж, тэдгээрийн үр дүнтэй байдалд тогтмол хяналт тавина** | | | | | |
| 18 | ***5.1. Компани нь эрсдэлийн удирдлагын заавар болон бүтэцтэй байх ба эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина.*** | Бүрэн хэрэгжүүлсэн. | "Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС"-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 06 сарын 14-ний өдрийн 21/007 дугаар тогтоолын Хавсралт А-гаар Эрсдэлийн удирдлагын журмыг баталсан. ТУЗ-өөс хяналт тавьж ажилладаг. | 2 | 100% |
| 19 | ***5.2. ТУЗ нь дэргэдээ эрсдэлийн удирдлага хариуцсан хороотой байхыг зорих ба уг хороо нь гурваас доошгүй тооны гишүүнтэй, дарга болон гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байна. Эрсдэлийн хорооны үйл ажиллагааны журам, бүтэц, бүрэлдэхүүнийг компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлж, тус хорооны хурлын ирц, хуралдсан асуудал, давтамжийн талаар тогтмол тайлагнана.*** | *"Компани энэхүү кодексийн засаглалын зарчмуудыг бүрэн хэрэгжүүлэхийг эрмэлзэх ба компанийн үйл ажиллагааны онцлог, бүтэц, хэмжээ, хөгжлийн үе шат зэргээс шалтгаалан зарим нэг зүйлийг тухайлан хэрэгжүүлэх боломжгүй, эсвэл зохион байгуулалтын илүү зохистой арга хэмжээг авч хэрэгжүүлж болно"* | Эрсдэл, аудитын хороог байгуулах, үйл ажиллагааны журмыг боловсруулах ажлыг хийж эхэлсэн. ТУЗ-ийн ээлжит хурлаар хэлэлцүүлэхээр бэлдсэн. | 2 | 80% |
| 20 | ***5.3. Компанийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл байгаа эсэхийг үнэлэн нийтэд мэдээлж, тэдгээр эрсдэлийг хэрхэн удирдаж буйгаа тайлбарлана.*** | Бүрэн хэрэгжүүлсэн. | Санг удирддаг "Мандал Ассет Менежмент ҮЦК" ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2022 оны 04 сарын 23-ны өдрийн 31 тоот тушаалын хавсралт №1 Ногоон хөгжлийн бодлого болон хавсралт №2 Нийгмийн хариуцлагын бодлогын баримт бичгийг батлан удирдаж буй сангууддаа хэрэгжүүлэн ажиллаж байна. | 2 | 100% |
| 21 | ***5.4. Компани нь комплайнсын хяналтын заавар болон бүтэцтэй байх ба комплайнсын хяналтын хэрэгжилтийн үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина.*** | Бүрэн хэрэгжүүлсэн. | Санг удирддаг "Мандал Ассет Менежмент ҮЦК" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 03 сарын 31-ний өдрийн 04 тоот тогтоолын 10-р хавсралтаар Комплайнсын хяналтын зааврыг баталсан. Комплайнсын хяналтыг хэрэгжүүлэх ажилтантай бөгөөд комплайнсын сургалтад хамруулдаг. | 2 | 100% |
| ДҮН | | | | 8 | 95% |
| **ЗУРГАА. ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ЦАЛИН УРАМШУУЛАЛ**<br>**Эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ нь компанийн алсын хараа, онцлогт тохирсон, шударга, ил тод байна** | | | | | |
| 22 | ***6.1. ТУЗ-ийн гишүүний цалин, урамшууллын*** | Бүрэн хэрэгжүүлсэн. | 2024 оны 04 сарын 22-ны өдрийн Нэгж эрх эзэмшигчдийн хурлаар Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын зардлыг баталсан. | 2 | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | ***хэмжээ, олгох хэлбэр, давтамжийг хувьцаа эзэмшигчийн хурлаар ил тод хэлэлцэж батална.*** | | | | |
| 23 | ***6.2. Компани цалин, урамшууллын хэмжээг тогтоох үндэслэл болсон ажил үүргийн бүрдэл хэсгүүд, ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг цалин, урамшууллын бодлогын баримтад тусгана.*** | Хөрөнгө оруулалтын сан нь ажилтангүй. | Хөрөнгө оруулалтын сан нь ажилтангүй бөгөөд Цалингийн зардал гаргадаггүй.<br><br>“Мандал Ассет Менежмент” ХХК-ийн ТУЗ нь Цалин урамшууллын бодлогын баримт бичгийг 2023 оны 03 сарын 31-ний өдрийн 04 тоот тогтоолын 14-р хавсралтаар баталсан. | 2 | 100% |
| 24 | ***6.3. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд гүйцэтгэх удирдлагын үндсэн цалин, шагнал бусад урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуурыг тусгана.*** | Бүрэн хэрэгжүүлсэн. | Хөрөнгө оруулалтын сан нь ажилтангүй бөгөөд Цалингийн зардал гаргадаггүй.<br>Гүйцэтгэх удирдлага нь Сангаас цалинждаггүй. Хөрөнгө удирдлагыг хэрэгжүүлдэг ХОМК-оос цалинждаг.<br>Сан нь зөвхөн хөрөнгө итгэмжлэн удирдах зардал ХОМК-руу шилжүүлдэг. | 2 | 100% |
| ДҮН | | | | 6 | 100% |
| **ДОЛОО. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ АШИГ**<br>**Компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх ашгийг хүндэлнэ** | | | | | |
| 25 | ***7.1. Компани нь ТУЗ-өөс баталсан бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах талаар бодлогын баримт бичигтэй байна. ТУЗ болон гүйцэтгэх удирдлага нь оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн, тэдэнтэй хамтран ажиллах байгууллагын соёлыг төлөвшүүлнэ.*** | Бүрэн хэрэгжүүлсэн. | “Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС”-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 06 сарын 14-ний өдрийн 21/007 дугаар тогтоолын Хавсралт А-гаар баталсан Хөрөнгө итгэмжлэн удирдах журам болон Нийтэд болон сангийн нэгж эрх эзэмшигчдэд мэдээлэл өгөх журмыг хэрэгжүүлдэг. Мөн ХОМК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 03 сарын 31-ний өдрийн 04 тоот тогтоолын 12-р хавсралтаар батлагдсан Оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах бодлогын баримт бичигт тусгасан | 2 | 100% |
| 26 | ***7.2. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд оролцогч талуудтай хамтран ажиллахдаа ямар асуудалд голчлон анхаарч, ямар стратеги баримтлан хэрхэн хэрэгжүүлж ажилласан талаар тусгана.*** | Бүрэн хэрэгжүүлсэн. | СЗХ-ны 2022 оны 05 сарын 25-ны өдрийн 275 тоот тогтоолоор батлагдсан “Хөрөнгө оруулалтын сан үүсгэн байгуулах, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түүнд хяналт тавих журам”-ын 17 дугаар зүйлийн 17.5 дахь хэсэгт заасан мэдээллийг үйл ажиллагааны журамдаа бүрэн тусгадаг. | 2 | 100% |
| 27 | ***7.3. Оролцогч талуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, харилцах зорилгоор компанийн цахим хуудсыг үр дүнтэйгээр ажиллуулна.*** | Бүрэн хэрэгжүүлсэн. | ХОМК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 03 сарын 31-ний өдрийн 04 тоот тогтоолын 12-р хавсралтаар батлагдсан Оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах бодлогын баримт бичигт тусгасан.<br>https://mandalasset.mn/ цахим хуудас болон олон нийтийн цахим сүлжээгээр дамжуулан тогтмол мэдээлэл хүргэдэг. | 2 | 100% |
| 28 | ***7.4. Компанийн ажилтнуудын санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх дотоод журам, нийгмийн асуудлыг шийдэх, мэргэжил дээшлүүлэх дотоод журам, ажлын төлөвлөгөөтэй байна.*** | Хөрөнгө оруулалтын сан нь ажилтангүй. | Хөрөнгө оруулалтын сан нь ажилтангүй. Үйл ажиллагааны онцлогоос хамаараад хэрэгжүүлэх шаардлагагүй зарчим гэж үзэж байна.<br>Сангийн ХОМК болох “Мандал Ассет Менежмент ҮЦК” ХХК-ийн Хөдөлмөрийн дотоод журам МАМ-ҮАЖ-001-2023-д ажилтнуудын санал, хүсэлт, гомдлыг шийдвэрлэх, сургалт хөгжил болон бусад асуудлыг тусгасан. | 2 | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 03 сарын 31-ний өдрийн 04 тоот тогтоолын 13-р хавсралтаар Өргөдөл, гомдлын журмыг баталсан. | | |
| ДҮН | | | | 8 | 100% |
| **НАЙМ. КОМПАНИЙН СОЁЛ**<br>**ТУЗ-ийн гишүүд компанид бизнесийн ёс зүйн өндөр хэм хэмжээг тогтоож, өөрсдөө манлайлан гүйцэтгэх удирдлага, ажилтнуудад мөрдлөг болгоно** | | | | | |
| *29* | ***8.1. Компанийн үнэт зүйлс, алсын харааг оновчтой тодорхойлж, хууль ёсны, ёс зүйтэй, хариуцлагатай үйл ажиллагаа явуулах зорилгоор ТУЗ нь ёс зүйн дүрмийг батлан, нийтэд мэдээлж, хэрэгжилтэд нь хяналт тавина.*** | Хөрөнгө оруулалтын сан нь ажилтангүй. | Хөрөнгө оруулалтын сан нь ажилтангүй.<br>ХОМК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 03 сарын 31-ний өдрийн 04 тоот тогтоолын 1-р хавсралтаар Ёс зүйн дүрмийг баталсан бөгөөд ТУЗ хяналт тавьдаг. | 2 | 100% |
| *30* | ***8.2. Аливаа хууль бус үйлдэл болон ёс зүйн зөрчлийг ТУЗ, эсвэл түүний дэргэдэх холбогдох хороонд мэдээлэх "шүгэл үлээгчийн" тогтолцоотой байна.*** | Бүрэн хэрэгжүүлсэн. | Хөрөнгө оруулалтын сан нь ажилтангүй.<br>ХОМК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 03 сарын 31-ний өдрийн 04 тоот тогтоолын 1-р хавсралтаар баталсан Ёс зүйн дүрмийн 3.2-т тусгасан. Мөн ХОМК-ийн Хөдөлмөрийн дотоод журамд тусгасан. | 2 | 100% |
| *31* | ***8.3. Ёс зүйн дүрмээр авлига, албан тушаалын гэмт хэргээс ангид байх болон улс төрийн үйл ажиллагааг дэмжих, /дэмжихгүй байх/ хандив өргөх /өргөхгүй байх/ талаар зохицуулна.*** | Бүрэн хэрэгжүүлсэн. | Хөрөнгө оруулалтын сан нь ажилтангүй.<br>ХОМК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 03 сарын 31-ний өдрийн 04 тоот тогтоолын 1-р хавсралтаар баталсан Ёс зүйн дүрмийн 2.5-т тусгасан. Мөн ХОМК-ийн Хөдөлмөрийн дотоод журамд тусгасан. | 2 | 100% |
| ДҮН | | | | 6 | 100% |
| **ЕС. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ**<br>**Компани болон ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн эрхийг хүндэтгэн тэгш хандаж, мэдээлэл авах болон эрхээ хэрэгжүүлэх боломжоор бүрэн хангана** | | | | | |
| *32* | ***9.1. Компани оролцогч талуудад өөрийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, засаглалын бүтэц, зохион байгуулалт, гүйцэтгэлийн үр дүнгийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа тухай бүр хүргэнэ.*** | Бүрэн хэрэгжүүлсэн. | "Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС" нь оролцогч талуудад өөрийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, засаглалын бүтэц, зохион байгуулалт, гүйцэтгэлийн үр дүнгийн талаарх мэдээллийг 2023 оны үйл ажиллагааны тайланд тусган өөрийн ХОМК-ийнхоо https://mandalasset.mn/ цахим хуудсаар дамжуулан хүргэдэг. | 2 | 100% |
| *33* | ***9.2. Компани хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөртэй байх ба тэдэнтэй харилцах, мэдээлэл солилцох цахим сувгийг хөгжүүлнэ.*** | Бүрэн хэрэгжүүлсэн. | "Мандал Ирээдүйн Өсөлт" нь өөрийн ХОМК-ийнхоо https://mandalasset.mn/ цахим хуудсаар дамжуулан хөрөнгө оруулагчидтай харилцдаг.<br>Мөн олон нийтийн цахим сүлжээгээр тогтмол мэдээлэл солилцдог. | 2 | 100% |
| *34* | ***9.3. Компани хувьцаа эзэмшигчийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, санал гаргах, санал өгөх, мэдээлэл авах зэрэг хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх боломж, нөхцөлийг бүрдүүлнэ.*** | Бүрэн хэрэгжүүлсэн. | "Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС" нь 2024 оны 04 сарын 22-ны өдөр Сангийн нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлыг амжилттай зохион байгуулсан билээ.<br>Хувьцаа эзэмшигч хуралд оролцох, санал гаргах, санал өгөх, мэдээлэл авах зэрэг хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх боломжоог бүрдүүлэхээр Сангийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 03 сарын 04-ний өдрийн 24/002 тоот "Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай" тогтоол | 2 | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | гарсан. Сангийн дүрэмд Нэгж эрх эзэмшигчийн эрх, үүргийг тусгасан. Тогтмол хэрэгжүүлж ажилладаг. | | |
| 35 | ***9.4. Компанийн үйл ажиллагааны чиглэл, өмчлөлийн бүтцийн асуудлаар хувьцаа эзэмшигчдээс санал өгөх эрхээ хэрэгжүүлэхэд нь онцгойлон анхаарна.*** | Бүрэн хэрэгжүүлсэн. | "Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС" нь 2024 оны 04 сарын 22-ны өдөр Сангийн нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлаар ирц, санал хураалт, асуулгыг www.investmentexpo.mn цахим хуудсаар хүлээн авч хэрэгжүүлсэн. | 2 | 100% |
| 36 | ***9.5. Компани болон хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхол зөрчигдөхөөс сэргийлэх зорилгоор сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журамтай байх ба хэрэгжилтийг нийтэд мэдээлнэ.*** | Бүрэн хэрэгжүүлсэн. | Сангийн дүрэмд сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зохицуулалтыг тусгасан ба сангийн ХОМК болох "Мандал Ассет Менежмент" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 03 сарын 31-ний өдрийн 04 тоот тогтоолын 3-р хавсралтаар Ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах журмыг баталсан. | 2 | 100% |
| ДҮН | | | | 10 | 100% |
| **НЭГДСЭН ДҮН** | | | | **69** | **94.3%** |

**-оОо-**